

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сугар	Дугаар	L227
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Бүрэгхангай сум
Төрсөн газар	Бүрэгхангай сум	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зүүн Соо гүний хүрээ	Сүм хийдийн дугаар	БУБУ 054
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 12	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат

Булган аймгийн Бүрэгхангай сумын Зүүн Соо гүний хүрээ

Д.Мөнхбат: За тэгэхээр та сайхан зусч сайхан амарч явна уу?

Сугар: Сайхан амарч байна.Сайхан зусч байна уу?

Д.Мөнхбат: Сайхан зусч байна. За тэгэхээр таниас би Зүүн Соо гүний хүрээний талаар товчхон ярилцлагыг хийх гэж сумын ИТХ-ын даргатай зорьж ирлээ.Соо гүний хүрээ гэсэн энэ хүрээний үүх түүхийг ярихаасаа өмнө зүүн Соо гүн , баруун Соо гүн гэж энэ Түшээт хан аймгийн урд зх нутгийн л одоо тухайн үеийн засаг захиргааны нэгж юмаа даа тиймээ? Зүүн Соо гүн нь одоо Бүрэгхангайд ,

Сугар:Баруун Соо гүн гэдэг чинь одоогийн Хишиг-Өндөрт

Д.Мөнхбат: Тэгэхээр энэ Зүүн Соо гүний хүрээний үйл ажиллагаа тэр шашны мандан бадралынхаа үед ямархуу хэмжээний хүрээ хийд, ямар ямар зан үйл явуулдаг байсан юм бол оо, таны бага насанд үзэж харснаар?

Сугар: Одоо 1000 гаран ламтай ,тийм том хүрээ хийд байсан гэж ярьдаг, 4 том дацантай гэлүү тэгж л ярьдаг байсан юм тэр үед.Одоо цам майдар бол...Зуны сүүл сарын 29-нд цам болдог байсан гэж бодож байна . Зуны эхэн сарын 29-нд цам болоод , зуны эхэн сарын 19-нд майдар эргэдэг байсан гэж бодож байна, андуурч байж магадгүй л дээ. Тийм л багцааны байсан байх. Тэгээд их том цамтай газар байсан ,манай энэ хүрээ чинь. Их том цамтай , хурдан цагаан...Ер нь янз бүрийн юмтай,тэр үеийн хамаг сайхан бүгдийг л хэрэглэж байсан газар байх гэж бодож байна. Бага байсан болохоор бас сайн ойлгохгүй мэдэхгүй байнаа. Ер нь их л лам нартай байсан даа .Сайхан сайхан лам нар зөндөө байсан даа хөөрхий.

Д.Мөнхбат: Энэ хүрээний гол шүтээн бурхан нь Вандан Лхам бурхан байсан гэж түүхэнд одоо хөгшчүүл ч ярьж, тэмдэглэж үлдээсэн байх юм. Та тэгэхээр тэр Вандан Лхам гэж гол шүтээн бурхныг нь харж үзэж байв уу, цогчин дуган луу нь орж мөргөл хийж байв уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сугар: Одоо Засгийн Чойжил гэж тэр цамаар гардаг байсан юм. Засгийн Чойжоо гарч ирэхгүй одоо бүр бүрээ бишгүүр болоод л тэгээд хүлээлгээд байдаг байсан юм. Манай энэ одоо хуучнаар бол 8-р Богдын үед амьдарч байсан юм. Балдан гэдэг хүн, тэр Засгийн Чойжилд гарч байсан. Тийм тоглож байж, дүр бүтээж тоглож байсан. За хурдан цагаан гэж бас байсан. Хурдан цагаанд бол манай нутгийн Далай Гэндэн гэж хүн тоглодог байсан. Одоо тийм тийм юмыг л би мэдэж байна. Тэрнээс нарийн ширийнийг нь сайн мэдэхгүй байна

Д.Мөнхбат: Энэ таны одоо мэдэж байгаа 1930-аад оны дунд үеэс хүрээ хийдийн одоо тухайн үеийн мандан бадралын төгсгөл үе байж дээ. Тэр үед хамгийн сүүлийн хамба нь ямар хүн байсан бол, Энд өөр одоо ямар ямар эрдэм чадалтай, нутгийн сүсэгтэн олны дунд домог болон яригддаг чадалтай эрдэмтэй лам нар ямар ямар хүмүүс байсан юм бол?

Сугар: Үгүй одоо нэг их содон нь юу байсйим, зүгээр нийт олон сайхан гавж нар олон сайхан маарамба улсууд зөндөө л байсан л даа. Тэгээд ер нь одоо сайн санахгүй л байна. Надад ирж нэг хэлж байсан юм. Манай ижийгийн ах дүү 2 бол том гавж нар байсан. Дамбий гавж, Цүлтэм гавж гэж...ийм улс байсан. Одоо бол Даржаа маарамба, Самбуу маарамба гэж том улс байсан. Миний өөрийн тэр өвгөн аавын хамаатан Даржаа эмч гэж бас том маарамба байсан юм. Бас баригдаад явсан...Маналжавын Даржаа гэдэг хүн байсан. Бас л хэрэгт ороод явчихсан даа

Д.Мөнхбат: Тэгэхээр монголын сүм хийдүүдийн түүхийг аваад үзэж байхад томоохон сүм хийдүүд нь ихэнхдээ дамжаа барьдаг байж тиймээ. Тэгэхээр дамжаа барина гэхээр жишээ нь гавжийн дамжаа гэдэг юмуу. Ингээд дамжаа барина гэхээр одоогоор бол тэр эрдмийн цол зэрэг хамгаалахтай л ойролцоо юм шиг байгаа юм. Тэгэхээр Зүүн Соо гүний хүрээнд дамжаа барьж байсан юм болов уу, одоо гавж маарамбуудыг төрүүлэх гэж ч юмуу, одоо танд санагдаж байгаа юм байна уу?

Сугар: Байгаа, байгаа. Гавж маарамба бол эндээ барьдаг байсан ганц лам байсан юм. Анх эхлээд дом хийнэ ш дээ тэд нар чинь. Дом хийхдээ бас л дамжаа барина ш дээ, шат шатаараа. Хамгийн баян хүн л одоо тэр дээд зэргийн 25 ч гэнэ үү тийм олон хүн оруулдаг дамжаа барьдаг байсан юм. Дарга нар ёстой тэвдсэн юмнууд.

Д.Мөнхбат: Хүрээ гэхээр одоо жассан бол нэлээн арвин байсан байх тиймээ, тэгэхээр энэ жас нь ер нь ямархуу байсан юм, ийм өргөн дэлгэр жастай байсан юм болов уу?

Сугар: Жасын мал малладаг улс гээд байдаг юм. Дээр үед жас нь мал маллаж байгаа юм гээд л байдаг байсан. Тэрнийг бол би сайн мэдэхгүй. Тэрнийг бол жаахан мал ядуутай улс л малладаг байсан болов уу гэж бодож байна. Манай ард бол жасын мал малладаг улс байсан. Тэд бол хувийн нээх малгүй, тийм улс байсан санагдаж байх юм. Хувьдаа малгүй нэг ёсны орлого ч байж болох юм д Тийм жасын малыг тийм улсууд малладаг байсан юм. Нарийн сайн мэдэхгүй юм даа.

Д.Мөнхбат: Тэгэхээр энэ Зүүн Соо гүний хүрээ түүхэн баримтаас үзэхэд 1723 онд анх тэр Баянхангай уулын өвөр бэлд шаваа тавьсан байх юм. Тэгэхээр тэндээс одоо тодорхой үед тэндээ байж байгаад бид нарын саяын гаргасан тооцоогоор 1880-1890-ээд оны үед одоогийн энэ туурь нь байгаа Бүрэгхангай сумын ар талд энэ Бүрээ толгойны өвөрт ирж суурьшжээ. Тэгэхээр та түрүүн бас нэг сонирхолтой хууч хэлэх гэж байсан. Тэгэхээр тэр

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Даваахангайн бэлээс энэ Шавартайн давааг давуулаад Бүрээ толгойн өвөрт хүрээг нүүлгэж ирэхэд таны аав юмаа даа тиймээ, бага залуу насандаа хүрээ нүүлгэлцэж явсан тухай өгүүлж байсан.Тэгэхээр энэ тухайгаа та бас сонирхуулж хэлэхгүй юу?

Сугар:Манай аав тэр хүрээг нүүлгэлцэж явахдаа 21настай байсан юм шиг байгаа юм.Тэгээд манай аав чинь, тэр үедээ танхай зэрлэг хүн байсан гэсэн. Тэгээд том бурхан ингээд үхэр тэргэн дээр ачиж явсан юм байгаа биз.Тэгээд чи тийм эрдэмтэй чадалтай юм бол наад үхрээ нүд гээд ташуураа өгч байсан гэсэн тэр бурханд.тэгж ярьж хөхрөлддөг юм

Д.Мөнхбат: Ерөөсөө тэгээд харж явж байгаад л дууссан уу тиймээ?

Сугар: Харж , харжявж байгаад л дууссан...

Д.Мөнхбат: Том бурхан үхэр тэргэн дээр ачиж явсан нь гол шүтээн нь байсан юм биш биз?

Сугар: Тийм байх, их том бурхан л гэж ярьдаг байсан юм

Д.Мөнхбат: За ямар ч байсан 19-р зууны сүүл орчим үед 1880 оны дундуур хүрээ хийд маань эндээ сурьшсан байж болох талтай юм байна тиймээ. Тэгэхээр 1937, 1938 оны үеийн тэр одоо цөвүүн цаг бурхны шашныг хавчиж , хясаж нөгөө эрдэм чадалтай лам нарыг нь барьж, хорьж сүм хийдийг нь нурааж байсан тэр цагийн эхэнд энэ хүрээ маань ямархуу байсан юм бол , ер нь монголын Буддын шашныг түүхийг аваад үзэхэд зарим нь лам нарыг нь барьж авч явчихаад ерөөсөө тэр намартаа юмуу өвөлдөө хийдийг нь шатаагаад хаячихсан байдаг, зарим нь одоо лам нарыг нь барьж явчихаад бүр хүрээ хийд эзгүйрээдбайдаг.1940, 1950-аад оны нүүрийг үзэж байгаад зарим нь бол бүр 1960-аад оныг хүртэл эзгүй байгаад байдаг.Тэгэхээр энэ Зүүн Соо гүний хүрээний тухай ямар байсан юм бол оо?

Сугар: Үгүй одоо тэр чинь хичнээн жил болсныг нь мэдэхгүй юм .Баригдаж Хэсэгтээ бол байж л байсан .Ганц хоёр жилдээ нүдэнд харагдаад байж л байсан ,эзгүйрээд л . Цаашдаа хэдэн жил байхыг нь бисайн мэдэхгүй юм .Одоо тэгээд лам нарыг чинь хурааж аваад л одоогоор бол худалдаа гаргаад худалддаг байсан ш дээ, өнөөх хувцас хунар бүх юмыг нь бас номыг нь хаяхыг нь хаяад л, дэвслэхийг нь дэвсээд л их л гамгүй эдэлж байсан даа тэр үед .аймшигтай л байсан.Зах зухыг нь л мэднэ нарийн нь сайн мэдэхгүй байна. Тэр болгон толгойруу орж ирдэггүй болохоор. Тэгж тэр дор нь шатаагаагүй байх, харин тэр үлдсэн улсууд нь мөн ах дүү нь байшин саваа хөдөө гаргаж барьж тэгж байсан болов уу гэж санаж байна

Д.Мөнхбат: 1000-аад ламтай байсан Зүүн Соо гүний хүрээнээс мэдээж их л эрдэм чадалтай лам нар хэлмэгдсэн байх даа.Эндээс одоо ер нь цаг бусаар мөнх бусыг үзүүлсэн лам нар хэд байдаг юм бол , он удаан жил шоронд суусан лам нар хэд байдаг юм бол, энэ талаар?

Сугар: 2 хүн л буцаж ирсэн юм, миний мэдэхийн 3 ч хүн буцаж ирсийм. Баривчлагдаж яваад. Санжаа гавж гэж ,Салын Санжаа гэж хүн буцаж ирсэн.Нэг маарамба , Хятад маарамба л гэсэн. Нэрийг нь сайн мэдэхгүй юм, Нэг нь Голио Даржаа гуай, ойрхноос буцаж ирсэн дээ.Тэгээд л бусад нь сураггүй болсон доо.Одоо манай тэр Даржаа гавж гэдэг ах бол хаана ч явсан нь мэдэгдэхгүй. Нөгөө 2 ах ч хаа явсан нь мэдэгдэхгүй, тэгээд л баригдаж яваад л тэгээд л байхгүй

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Д.Мөнхбат: Энэ одоо сумын төв дээр байж байгаа хийд шинээр баригдсан дуган тиймээ.1991 онд байгуулагдсан.Энэ дуганы год шүтээн Вандан Лхам бурхныг зүүн Соо гүний гол шүтээн бурхан мөн, хэлмэгдүүлэлтийн их шуурган дотор шатаагдчихгүй, эндэгдчихгүй байж байгаад хотод Гандантэгчин лэн хийдэд залагдаж байж: байгаад 1991 онд залж ирсэн гэсэн мэдээллийг авсан юм. Тэгэхээр та энүүгээр орж үзэв үү, жинхэнэ тэр шүтээн нь мөн юм болов үү?

Сугар: Үгүй ээ, манай хүн байхдаа биш байна л гэж хэлж байсан юм. Амьд сэрүүн байхдаа, очсон адилгүй юм байна л гэж байсан.Энийг сайн мэдэхгүй.

Д.Мөнхбат: За танд баярлалаа. Таны өгсөн энэ мэдээлэл манай “Монголын сүм хийдийн түүхэн товчоо” төслийн судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Сугар: За баярлалаа. Та бүхэнд ажлын амжилт сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Д.Мөнхбат:Та урт насалж удаан жаргаарай. Танд маш их баярлалаа